

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН
СОЛОНГОС ХЭЛНИЙ БАГШ ЭРДЭНЭХИШИГ ОВОГТОЙ БҮРЭНЖАРГАЛЫН
2019 – 2020 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**



2019.12.26

ТОВЬӨОГ

1. Багшийн үйл ажиллагааны төлөвлөгөө
2. Стандарт хэрэгжилт
3. Хөтөлбөр төлөвлөгөө
4. Багшийн хөгжил – оролцоо
5. Багшийн өөрийн болон сурагчийн амжилт
6. АУБ-ын үйл ажиллагаа
7. Эцэг эхийн оролцоо – хамтын ажиллагаа

1. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

№	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Хүлээж буй үр дүн
1	Солонгос хэлний хичээлийн хөтөлбөр төлөвлөгөө, сурагчдын оношилгоог бодитойгоор гаргах	2019.09.01- 2019.09.30	3 - 12 дугаар ангийн хөтөлбөр төлөвлөгөө хийж баталгаажуулсан. Хичээл ордог ангиудад гарааны оношлогоо хийсэн. Бүлэг сэдэв болон нэгж хичээлээр үнэлэх үнэлгээний даалгаврын сан бүрдүүлэх, сурагчдыг үнэлэх, дэвтэр шалгах, анализ хийх, MOODLE систем дээр хөтөлбөр оруулах, шалгалтын материал боловсруулах үйл ажиллагааг хийж байна.
2	Мэргэжлийн нийслэл, дүүргийн сургалт, семинарт цаг тухай бүрт нь хамрагдах	2019.09.01- 2020.05.31	Мэргэжлийн семинарт байнга идэвхтэй оролцож, олж авсан мэдлэгээ үйл ажиллагаандаа ашиглаж байна.
3	Сургуулийн сургалтууд, ЗАН-ийн нэгдэл секцийн арга зүйн ажилд хамрагдах	2019.09.01- 2020.05.31	Сургуулиас зохион байгуулж буй сургалтуудад байнга хамрагдан өөрийгөө тодорхой хэмжээнд хөгжүүлж байна.
4	Сургуулиас зохион байгуулагдаж буй цаг үеийн ажилд оролцох	2019.09.01- 2020.06	Ангийн сурагчдын болон өөрийн мэдээллийг сургуулийн дотоод сүлжээ болон БСШУСЯ-ны “esis.edu.mn” сайтад мэдээллийг шинэчлэх, ээлжит хэчээлийн ирц, сэдэв, дүнг оруулах үйл ажиллагаанд оролцож байна
5	Англи, Солонгос хэлний түвшингээ ахиулах	2019.11-2020.06	Солонгос хэлний гүнзгий шатыг Бие даан судлах-Ном, CD, интернет ашиглах
6	Боловсрол судлал, сэтгэл судлалын ном зохиол уншиж аргазүйгээ дээшлүүлэх	2019.09.01- 2020.05.30	Сурган хүмүүжүүлэх ажилд хэрэгтэй мэдээ мэдээллийг авч сургалтаа сайжруулан ажиллаж байна
6	Дааж ажиллаж буй 11г ангийн сурагчдыг байнга зөв чиглүүлэн, удирдах	2019.09.01- 2020.05.30	Ангийн буланг байнгын тогтмол үйл ажиллагаатай болгох, ангийн сурагчдын сурлага, хүмүүжил, төлөвшилд байнга хяналт тавин, зөв үлгэрлэх, зааж сургах, зөвөлгөө өгөн ажиллаж байна.
7	Ангитай болон хичээл ордог ангийнхаа сурагчидтай ажиллах цагийг үр бүтээлтэй	2019.09.01- 2020.05.30	Хоцрогдсон сурагчдад цаг гарган байнгын хамтран ажиллаж байна.

	ашиглан сурагчдыг судлан, судалгаанд үндэслэн сурагчидаа хөгжүүлэх нэмэлт давтлага өгөх		
--	---	--	--

2. СТАНДАРТ ХЭРЭГЖИЛТ

А) Нэгдүгээр хагас жилийн дүнгийн нэгтгэл

№	Анги	Дүгнэгдвэл зохих	Дүгнэгдсэн сурагчдын тоо	Даалгаваруудын гүйцэтгэл								Гүйцэтгэлийн Чанар
				I	II	III	IV	V	VI	VII	VIII	
1	3г	33	33					10	13	6	4	70%
2	4г	32	32					11	9	9	3	66%
3	5г	30	30					5	5	13	7	83%
4	6г	24	24				3	14	2	3	2	21%
5	8г	23	23					10	2	5	6	48%
6	10г	16	16						8	5	3	50%
7	11г	24	24					1	2	7	14	88%
8	12г	19	19						2	5	12	90%
8		201	201				3	51	43	53	51	65%

ДҮГНЭЛТ

Тус хагас жилд нийт 8 ангийн 201 сурагчдад солонгос хэлний хичээлийг заасан бөгөөд гүйцэтгэлийн чанарын үзүүлэлт дундажаас дээш буюу 65 % аар дүгнэгдсэн байна.

Дээрх үнэлгээг харвал бдугаар ангийн 3 сурагч IV түвшинд үнэлэгдсэн байгаа ба дээрх нэр бүхий гурван сурагчид дэмжлэг хэрэгтэй гэдэг дүгнэлтэнд хүрч байна

Тус сурагчдын хувьд ерөнхий хичээлд болон даалгаварын гүйцэтгэлийн хувьд дутуу дулимаг ханддаг, эцэг эхтэй удаа дараа холбогдсон ч тодорхой үр дүнд хүрээгүй тул ирэх гуравдугаар улиралд илүү анхааран нэмэлт давтах байдлаар хичээлийг явуулах хэрэгтэй байна гэдэг дүгнэлтэнд хүрч байна.

3. ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БОЛОВСРУУЛАЛТ

2019 – 2020 оны хичээлийн жилийн хагас жилд нийт 3 – 12 дугаар ангийн нийт 8 ангийн хичээлийн төлөвлөлт хийсэн ба тус бүрийг Мүүдл системд байршуулсан бөгөөд нийт 29 нэгж хичээлийг байрлуулсан ба үүнээс дурьдвал: Бага бүлгийн 3,4,5,6-р ангиудын нийт 17 нэгж хичээл, дунд бүлгийн 8-р ангийн нийт 4 нэгж хичээл, ахлах бүлгийн 10,11,12-р ангийн нийт 8 нэгж хичээлийг тус системд байршуулахдаа ярих, сонсох, бичих, унших зэрэг гадаад хэлний үндсэн дөрвөн чадвараар болон тус бүрийг ээлжит хичээл хэлбэрээр PPD хийж байршуулсан болно.

/хавсралтаар зурагт хэлбэрээр оруулсан болно/

4. БАГШИЙН ХӨГЖИЛ - ОРОЛЦОО

А) мэргэжил дээшлүүлэлт

2019 – 2020 оны хичээлийн жилийн намрын семестрд МУИС-ийн ХИС-ийн Солонгос судлалын тэнхимд магистрын зэргийн хамгаалалтанд амжилттай орж магистрын зэргийг амжилттай хамгааллаа. Тус семестрийн хугацаанд: Боловсролын харилцаа, сурган сэтгэлзүйн оношлогооны аргазүй хичээлүүдийг судласан бөгөөд солонгос хэлний сургалт болон даасан ангийн сурагчдыг хэрхэн удирдана явуулах хэрэгтэйг шинээр ойлгож суралцлаа.

Б) Сургалт семенарт хамрагдсан байдал

Хичээлийн жил эхлэхийн өмнө Нийслэлийн боловсролын газраас зохион байгуулсан сургалтын хөтөлбөрийн боловсруулалтын аргазүйн сургалтанд амжилттай хамрагдсан. Мөн нийслэлийн боловсролын газар болон БНСУ-ын Гёнги аймаг, МУ дахь смарт анги хэрэгжүүлэгч байгуулгын хамтарсан солонгос хэлний багш нарын чадваржуулах сургалтанд амжилттай хамрагдсан болно. Тус сургалтын хугацаа нь: 2019.12.02 – 12.06 ны хооронд Багшийн хөгжлийн ордонд явагдав.

Түүнчлэн Монголын ерөнхий боловсролын дунд сургуулийн солонгос хэлний багш нарын холбооноос сар бүрийн 2 долоо хоногийн амралтын өдрүүдэд зохион байгуулагддаг мүүдл систмийн хэрэглээ болон заах аргазүйн сургалтанд тогтмол оролцож байна.

С) Ажлын байр дээр хөгжсөн байдал

Өнгөрсөн хичээлийн жилээс тус сургуулийн сурагчдад шинээр хэрэглэгдэж байгаа сурах бичгийн контентийг зохиож тус номыг цахимжуулах ажлыг хичээлийн бус цагаар хийж, шинэ хэрэглээний

програм болон солонгос хэлний мэдлэгийг ахиулж байна. Мөн ахлах ангийн анги удирдсан багшийн хувьд анги удирдах урлагт суралцаж байна.

Д) Багшийн оролцоо

Солонгос хэлний улсын XIII олимпиадын ерөнхий зохион байгуулалтанд оролцсон бөгөөд бие даан тус олимпиадын бичих ур чадварын уралдааны төлөвлөлтийг гаргаж зохион байгуулсан. Мөн олимпиадын нээлтийн үйл ажиллагаа, ярианы тэмцээн, шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааны хөтөлгчийн үүргийг амжилттай гүйцэтгэсэн.

Мөн МУИС дээр зохион байгуулагддаг олон улсын солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын хянагч багшийн сургалтанд хамрагдаж хянагч багшаар ажилласан 2019.10.26

5. БАГШИЙН ӨӨРИЙН БОЛОН СУРАГЧИЙН АМЖИЛТ

Багшийн : Сургуулийн ур чадварын уралдаанд “Шилдэг технологитой багш” аар шалгарсан

Солонгос хэлний улсын XIII олимпиадын “Шилдэг багш” аар өргөмжлөгдсөн, ЧД-ийн Бусад гадаад хэлний багш нарын ур чадварын уралдаанд 1р байр, Нийслэлийн Бусад гадаад хэлний багш нарын ур чадварын уралдаанд 1р байр тус тус хүртэв. МУИС ХИС-ийн шилдэг оюутан магистрантуудад олгогддог Солонгос сангийн тэтгэлэг хүртэж магистраа ямар нэгэн санхүүгийн бэрхшээлгүйгээр амжилттай төгслөө

Сурагчийн : Солонгос хэлний улсын XIII олимпиадын дунд ангийн төрөлд 8г ангийн сурагч А.Цолмон нэгдүгээр байр, ахлах ангийн төрөлд 1г ангийн сурагч Г.Мөнхцэцэг гутгаар байр, Гадаад ахлах төрөлд 1г ангийн сурагч Х.Ганцэцэг нэгдүгээр байр эзэлсэн амжилттай байна.

6. АУБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019-2020оны хичээлийн жилд 16 - эрэгтэй сурагч . 31 - эмэгтэй сурагч буюу нийт 47 сурагчтайгаар хичээллэж байна.

I. Ангийн амжилтаас дурдвал:

“эх орон, тусгаар тогтнол” сэдэвт уралдаанд эцэг эхийн зөвлөлийн хариуцсан ханын сонингоор дүүрэгт 2р байр эзэлсэн.

II. Сурагчдын амжилтаас дурдвал:

Хүрэлбат овогтой Ганцэцэг нь солонгос хэлний улсын 13р олимпиадын тэргүүн байр мөн топикийн 6-р түшинг хангасан. Ганбат овогтой Мөнхцэцэг нь тус олимпиадын 3р байр. Мөн “Хор баяртай” нийслэлийн ЕБСургуулиудын дунд зохион байгуулагдсан уралдааны эссэ бичлэгийн төрөлд 3р байр англи хэлний түвшин тогтоох TOEFL шалгалтын 3р түвшин. солонгос хэлний топик шалгалтын 4р түвшин. Ази номхон далайн холбоотон орнуудын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулагдсан эссэ бичлэгийн тэмцээнд тусгай байр эзэлсэн байна. Энхтайван овогтой Санчир нь Моносын нэрэмжит нийслэлийн волейболлийн аварга шалгаруулах тэмцээний шилдэг хамгаалагч хүрэл медал, “Эх орон тусгаар тогтнол” сургуулийн илтгэлийн тэмцээнд 3р байр, “Яг одоо шинжилгээндээ” дэвжээ тэмцээнд дэд болон тэргүүн байр эзэлж амжилт гаргасан. Төрмөнх овогтой Мишээл нь Хюго энд колорс хүүхдийн урлагийн клубын нэрэмжит улсын гар зургийн олимпиад хүрэл медал, “Өөрчлөлтийг та бид хийнэ” сэдэвт дүүргийн дэвжээ тэмцээнд 2р байр эзэлжээ. Сурагч Гантөмөр овогтой Номин-эрдэнэ нь SHANGRILLA FASHION SHOW, GOYOL 2020, BASEMENT FASHION SHOW, BAYANMONGOL COLLECTION зэрэгт загвар өмсөгчөөр оролцож ҮНСГЭЛЖИН 2020 улсын уралдааны загвар өмсөгчийн төрлөөр 1р байр эзэлсэн. Ган-эрдэнэ овогтой Эрмүүн нь чингэлтэй дүүргийн хүүхдийн холбооны тэргүүн ба нийслэлийн зурагзүйн олимпиадын 1р байр, дүүргийн математикийн олимпиадын 7р байр болон нийслэлд орох эрх зэргээр тус тус амжилт гаргасаар байна.

III. Манай ангийн нийгмийн идэвхи оролцоо:

Сургуулийн “эмч” клубд 2 сурагч, “Өсвөрийн цагдаа” бүлгэмд 5н сурагч, тус бүлгэмийн Тэргүүн Э.Санчир, Сургуулийн Сурагчдын өөрөө удирдах байгууллагад 8 Сурагч байдаг ба тэргүүнээр С.Үүрийнтуяа дэд тэргүүнээр Г.Эрмүүн ажиллаж байна. ЧД-ийн Хүүхдийн холбоонд манай ангийн 3 сурагч байдаг ба тус холбооны Тэргүүнээр сурагч Г.Эрмүүн ажиллаж байгаа.

IV. Ангийн оролцоог дурдвал:

Солонгос хэлний улсын 13р олимпиадын шагнал гардуулах ёслолын угталтыг хариуцаж ажилласан. Мөн морин хуурын тоглолтоор оролцсон бөгөөд Шагнал гардуулах үйл ажиллагааг АУБ болон сурагч Э.Санчир хөтлөн явуулсан.

V. Ангийн Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт Топикийн мэдээллээс:

6р түвшинг –3сурагч, 4р түвшинг-7 сурагч, 3р түвшинг-18 сурагч хангасан байгаа бөгөөд ангийн 70хувь нь 11р ангид эзэмшвэл зохих түвшинг хангасан байна.

VI. Ангийн таслалт хоцролтын мэдээллээс:

Манай ангийн тасласан цаг нийт 329 ба үүнээс сурагч Ч.Дөлгөөн 269 цаг, Т.Тэмүүжин 45 цаг, Бат.Хүслэн 8цаг, С.Үүрийнтуяа 7цаг тасласан байна.

Хоцорсон 79 цаг байгаагаас хамгийн их хоцролтыг Б.Индра 13, П.Галбадрах 11цаг, Х.Ганцэцэг 5цаг, Т.Тэмүүжин 7цаг, Б.Ууганбаяр 5цаг, Б.Халиун 6цаг, Ба.Хүслэн 6цаг, Б.Цалгиун 5цаг – 53 цагийг эзлэж байна.

VII. Ангийн сурагчдын эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл

Амралтын хугацаанд бүх сурагчид цээжний рентгэн зураг авхуулж, сүрьеэгийн сорил тавиулсан Эцэг эхийн В,С-ийн судалгаа аван сургуулийн эмчид өгөв.

Ангийн ариун цэврийн булангийн мэдээллийг байнга шинэчлэн, мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байсан. Томуу ба томуу төст халдварт өвчнөөс хэрхэн сэргийлэх зөвөлгөө өгөн, яаж урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг Сургуулийн эмч И.Соёлмаа яриа таниулга хийсэн. 11 дүгээр ангийн бүлэг нэгдлээрээ бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт мэргэжлийн эмчээс авсан

7. ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦОО – ХАМТЫН АЖИЛЛАГАА

I. Мэргэжлийн багш

Мэргэжлийн багшийн хувьд анги тус бүрийн анхаарах шаардлагатай сурагчдын эцэг эхтэй тогтмол уулзаж суралцагчийн талаарх мэдээлэл өгч түүнчлэн аргазүйн зөвөлгөө өгч хамтарч ажиллаж байна.

II. АУБ

Эцэг эхийн хурлыг 2 удаа зохион байгуулсан бөгөөд Эцэг эхийг багт хуваан, багууд сурагчдын хүсэлтээр шаардлагатай лектерүүдийг ангидаа урьж мэдээ мэдээллээр хангаж байна. Одоогийн байдлаар 3 лекц сурагчдад уншигдсан байна.

Түүнчлэн ангийн анхаарах шаардлагатай сурагчдын мэдээллийг сургуулийн нийгмийн ажилтан болон хяналтын ажилтанд мэдэгдэж тус сурагчийг анхаарах тал дээр хамтарч ажиллаж байна.